

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-/34/2023-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/198
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.ОТГОНБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Засаг даргын тамгын газар нь Эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтын хүрээг нэмэгдүүлэх зорилгоор “Шинэ сэргэлтийн бодлого – Хөгжлийн түүчээ – Төв аймаг” эдийн засгийн чуулганыг зохион байгуулж 20 төсөл арга хэмжээний хүрээнд 814 тэрбум төгрөгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулж хамтран ажиллаж байна. Аймгийн эдийн засгийн голлох салбар болсон Хөдөө аж ахуйн салбарт: 2022 оны жилийн эцсийн тооллогоор мал сүрэг 5,100.0 мянган толгойд хүрч улсдаа 3-р байр, тариаланчид, ногоочид 308.0 мянган тонн ургац хураан авч төмс, ногоон тэжээлийн ургацаараа улсдаа тэргүүн байр эзэлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторов мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 дугаар тогтоолоор “Газрын дуудлага худалдааны орлогыг төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах” журмын дагуу нэмэлт санхүүжилтийн дансанд 1,316,015.8 мянган төгрөгийг хүлээн авч зарцуулсан байна.
- Нийт 3 аж ахуйн нэгжтэй холбоотой 101,650.0 мянган төгрөгийн худалдан авалтыг худалдан авах ажиллагаа зарлалгүй хийсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	173,012,400.00	337,510,640.00
33	АВЛАГА	4,015,663.00	129,039,113.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,958,000.00	126,981,450.00
33500	Бусад авлага	2,057,663.00	2,057,663.00
33510	Байгууллагаас авах авлага	2,057,663.00	2,057,663.00
35	БАРАА МАТЕРИАЛ	168,996,737.00	208,471,527.00
35100	Түүхий эд материал	19,429,952.00	19,429,952.00
35110	Тусгай зориулалттай материал	19,429,952.00	19,429,952.00
35400	Хангамжийн материал	149,566,785.00	189,041,575.00
35410	Бичиг хэргийн материал	4,159,800.00	1,200,300.00
35420	Аж ахуйн материал	145,202,554.00	185,183,713.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0	210,000.00
35440	Түлш, шатах тослох материал	204,431.00	2,447,562.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,254,718,576.81	3,304,165,986.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,254,718,576.81	3,304,165,986.90
39200	Биет хөрөнгө	3,053,098,689.23	3,048,232,765.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,894,783,325.00	2,907,716,446.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-226,233,651.61	-303,892,298.53
39203	Авто-тээврийн хэрэгсэл	644,600,000.00	556,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-461,283,333.62	-432,683,333.42
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	459,521,317.04	631,223,732.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	-339,230,384.71	-373,140,018.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	323,815,158.35	323,815,158.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-244,855,426.02	-260,906,011.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	76,275,191.00	76,275,191.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-74,293,506.20	-76,176,099.79
39300	Биет бус хөрөнгө	201,619,887.58	255,933,221.02
39301	Програм хангамж	35,500,000.00	95,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-17,180,112.42	-22,866,778.98
39303	Бусад биет бус хөрөнгө	183,300,000.00	183,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,427,730,976.81	3,641,676,626.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	210,000.00	455,490.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	210,000.00	455,490.00
41300	Өглөг	210,000.00	455,490.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	210,000.00	455,490.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,427,520,976.81	3,641,221,136.90
51	Засгийн газрын хувь оролцоо	3,427,520,976.81	3,641,221,136.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,633,996,434.32	1,633,996,434.32
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,633,996,434.32	1,633,996,434.32
51200	Хуримтлагдсан үр дүн	662,897,039.79	882,584,432.88
51210	Өмнөх үеийн үр дүн	670,346,078.34	668,884,272.79
51220	Тайлант үеийн үр дүн	-7,449,038.55	213,700,160.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,130,627,502.70	1,124,640,269.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,427,730,976.81	3,641,676,626.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,350,339,820.00	4,764,632,548.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	226,414,188.00	92,843,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	226,414,188.00	92,843,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	81,091,389.00	15,850,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,273,699.00	15,850,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,817,690.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	113,995,599.00	62,993,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	31,327,200.00	14,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,123,925,632.00	4,671,789,048.17
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,806,259,832.00	1,648,646,748.17
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,733,307,617.00	208,343,646.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	72,952,215.00	1,440,303,102.17
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,317,665,800.00	3,023,142,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	4,317,665,800.00	3,023,142,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,357,788,858.55	4,550,932,388.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,357,788,858.55	4,550,932,388.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,397,191,620.55	3,911,869,220.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,159,536,926.89	1,222,200,667.50
210101	Үндсэн цалин	723,200,789.89	827,428,410.80
210102	Нэмэгдэл	0	71,182.00
210105	Гэрээт ажлын хөлс	436,336,137.00	394,701,074.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,264,907.11	147,845,082.50
210201	Тэтгэврийн даатгал	103,357,808.11	101,491,669.50
210202	Тэтгэмжийн даатгал	11,087,948.00	11,461,236.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,870,361.00	9,168,989.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,190,063.00	2,199,602.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,758,727.00	23,523,586.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	283,206,769.00	303,014,549.00
210301	Гэрэл, цахилгаан	26,691,245.00	28,174,254.00
210302	Түлш, халаалт	243,667,304.00	263,382,988.00
210303	Цэвэр, бохир ус	12,848,220.00	11,457,307.00
2104	Хангамж, бараа материалын зардал	329,646,063.00	80,276,524.00
210401	Бичиг хэрэг	18,040,535.00	15,732,640.00
210402	Тээвэр, шатахуун	39,735,176.00	41,622,519.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,633,024.00	11,981,865.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	259,237,328.00	10,939,500.00
2105	Нормативт зардал	1,338,115.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,338,115.00	0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	335,000.00	455,436,372.00
210604	Урсгал засвар	335,000.00	455,436,372.00
2107	Томилолт, зочны зардал	16,185,000.00	19,830,000.00
210701	Гадаад албан томилолт	4,000.00	0
210702	Дотоод албан томилолт	16,181,000.00	19,830,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	149,679,123.00	138,617,932.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,142,049.00	129,998,747.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	850,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	2,083,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	966,722.00	426,098.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	356,360.00	264,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,863,992.00	4,996,087.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,307,999,716.55	1,544,648,093.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,097,286,539.00	1,285,281,066.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,722,300.00	64,178,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	203,990,877.55	195,188,126.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	960,597,238.00	639,063,168.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,260,280.00	57,529,221.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	52,762,819.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,260,280.00	4,766,402.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	954,336,958.00	581,533,947.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	917,211,453.00	86,109,376.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	37,125,505.00	495,424,571.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-7,449,038.55	213,700,160.09
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-7,449,038.55	213,700,160.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,205,017,021.00	4,667,767,732.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,273,699.00	15,850,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	50,273,699.00	15,850,200.00
1E+05	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,273,699.00	15,850,200.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,273,699.00	15,850,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,154,743,322.00	4,651,917,532.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,837,077,522.00	1,628,775,232.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,733,307,617.00	208,343,646.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	103,769,905.00	1,420,431,586.80

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,317,665,800.00	3,023,142,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	4,317,665,800.00	3,023,142,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,117,890,146.00	4,472,867,732.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,117,890,146.00	4,472,867,732.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,157,292,908.00	3,833,804,564.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,159,512,219.00	1,065,952,988.99
210101	Үндсэн цалин	541,479,709.00	616,385,548.99
210102	Нэмэгдэл	129,219,293.00	220,301,265.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,550,730.00	67,367,670.00
210104	Урамшуулал	23,685,742.00	62,947,455.00
210105	Гэрээт ажлын хөлс	419,576,745.00	98,951,050.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,839,246.00	136,916,916.01
210201	Тэтгэврийн даатгал	104,588,492.00	94,336,825.50
210202	Тэтгэмжийн даатгал	10,093,400.00	10,644,772.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,074,700.00	8,275,577.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,861,300.00	2,369,194.50
210205	Эрүүл мэндийн даатгал	21,221,354.00	21,290,545.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	283,682,540.00	302,900,295.00
210301	Гэрэл, цахилгаан	26,691,244.00	28,060,000.00
210302	Түлш, халаалт	243,667,304.00	263,382,988.00
210303	Цэвэр, бохир ус	13,323,992.00	11,457,307.00
2104	Хангамж, бараа материалын зардал	320,667,847.00	76,985,335.00
210401	Бичиг хэрэг	14,663,895.00	9,878,100.00
210402	Тээвэр, шатахуун	34,204,000.00	44,283,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,562,624.00	11,884,635.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	259,237,328.00	10,939,500.00
2105	Нормативт зардал	5,072,000.00	7,917,688.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,072,000.00	7,917,688.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,384,139.00	475,802,262.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,322,500.00	0
210604	Урсгал засвар	9,061,639.00	475,802,262.00
2107	Томилолт, зочны зардал	16,181,000.00	19,830,000.00
210702	Дотоод албан томилолт	16,181,000.00	19,830,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,902,367.00	286,929,742.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,909,645.00	257,697,227.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	850,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	2,083,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	966,722.00	426,098.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	500,000.00	264,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,176,000.00	25,609,417.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,114,051,550.00	1,460,569,337.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,103,062,200.00	1,394,336,437.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,989,350.00	66,232,900.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	960,597,238.00	639,063,168.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,260,280.00	57,529,221.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	52,762,819.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,260,280.00	4,766,402.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	954,336,958.00	581,533,947.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	917,211,453.00	86,109,376.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	37,125,505.00	495,424,571.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	87,126,875.00	194,900,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	87,126,875.00	194,900,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	87,126,875.00	194,900,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	87,126,875.00	194,900,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	87,126,875.00	194,900,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-87,126,875.00	-194,900,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,633,996,434.32	1,134,526,062.70	666,447,518.34	3,434,970,015.36
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	3,898,560.00	3,898,560.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,633,996,434.32	1,134,526,062.70	670,346,078.34	3,438,868,575.36
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-3,898,560.00	0	-3,898,560.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-7,449,038.55	-7,449,038.55
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,633,996,434.32	1,130,627,502.70	662,897,039.79	3,427,520,976.81
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,633,996,434.32	1,130,627,502.70	662,897,039.79	3,427,520,976.81
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	-5,987,233.00	5,987,233.00	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,633,996,434.32	1,124,640,269.70	668,884,272.79	3,427,520,976.81
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	213,700,160.09	213,700,160.09
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,633,996,434.32	1,124,640,269.70	882,584,432.88	3,641,221,136.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,035,142,300.00	2,952,883,124.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,975,142,300.00	2,892,883,124.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,912,450,600.00	2,835,353,903.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,071,907,600.00	1,050,392,161.00
210101	Үндсэн цалин	602,310,100.00	604,842,206.00
210102	Нэмэгдэл	227,976,700.00	218,572,952.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,537,000.00	65,534,670.00
210104	Урамшуулал	53,083,800.00	62,491,283.00
210105	Гэрээт ажлын хөлс	139,000,000.00	98,951,050.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,946,300.00	134,987,848.00
210201	Тэтгэврийн даатгал	100,070,000.00	92,565,648.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,719,100.00	10,605,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,335,300.00	8,244,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,383,800.00	2,361,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,438,100.00	21,211,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	304,813,300.00	302,900,295.00
210301	Гэрэл, цахилгаан	28,060,000.00	28,060,000.00
210302	Түлш, халаалт	264,291,200.00	263,382,988.00
210303	Цэвэр, бохир ус	12,462,100.00	11,457,307.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,161,200.00	66,045,835.00
210401	Бичиг хэрэг	9,878,100.00	9,878,100.00
210402	Тээвэр, шатахуун	44,283,100.00	44,283,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,000,000.00	11,884,635.00
2105	Нормативт зардал	9,436,700.00	7,917,688.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,436,700.00	7,917,688.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,490,100.00	46,490,100.00
210604	Урсгал засвар	46,490,100.00	46,490,100.00
2107	Томилолт, зочны зардал	19,944,000.00	19,830,000.00
210702	Дотоод албан томилолт	19,944,000.00	19,830,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	303,212,300.00	276,930,732.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	272,382,300.00	247,698,217.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	850,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,083,300.00	2,083,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.00	426,098.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	500,000.00	264,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	26,396,700.00	25,609,417.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	947,539,100.00	929,859,244.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	944,205,800.00	926,525,944.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,333,300.00	3,333,300.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,691,700.00	57,529,221.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,691,700.00	57,529,221.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,525,000.00	52,762,819.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,166,700.00	4,766,402.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,000,000.00	60,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	60,000,000.00	60,000,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,035,142,300.00	2,952,883,124.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,023,142,300.00	2,937,032,924.00
320001	Орон нутгийн төсвөөс	3,023,142,300.00	2,937,032,924.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	12,000,000.00	15,850,200.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,000,000.00	15,850,200.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	74	74
620001	Удирдах ажилтан	10	10
620002	Гүйцэтгэх ажилтан	33	33
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	28	28

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,837,077,522.00	1,628,775,232.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,837,077,522.00	1,493,875,232.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,798,791,737.00	998,450,661.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,697,571.00	15,560,827.99
210101	Үндсэн цалин	15,697,571.00	11,543,342.99
210102	Нэмэгдэл		1,728,313.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		1,833,000.00
210104	Урамшуулал		456,172.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,042,936.00	1,929,068.01
210201	Тэтгэврийн даатгал	2,042,936.00	1,771,177.50
210202	Тэтгэмжийн даатгал		39,472.47
210203	ҮОМШӨ-ний даатгал		31,577.98
210204	Ажилгүйдлийн даатгал		7,894.50
210205	Эрүүл мэндийн даатгал		78,945.56
2104	Хангамж, бараа материалын зардал	259,237,328.00	10,939,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	259,237,328.00	10,939,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		429,312,162.00
210604	Урсгал засвар		429,312,162.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,554,645.00	9,999,010.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийглэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72,554,645.00	9,999,010.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,449,259,257.00	530,710,093.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,441,915,257.00	467,810,493.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,344,000.00	62,899,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,285,785.00	495,424,571.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,160,280.00	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,125,505.00	495,424,571.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	37,125,505.00	495,424,571.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		134,900,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		134,900,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		134,900,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,837,077,522.00	1,628,775,232.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,837,077,522.00	1,628,775,232.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,733,307,617.00	208,343,646.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	103,769,905.00	1,420,431,586.80

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар нь төрийн үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх замаар аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тогтвортой өсөлтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн захиргааны байгууллага юм.

Төв аймгийн Засаг даргын тамгын газар нь тайлант онд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны шинэ тутам харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.
- Эдийн засгийн бүтэц дэх боловсруулах үйлдвэр, үйлчилгээний салбарыг дэвшилтэт технологи, инновацад суурилан хөгжүүлж, ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг 10 хувьд хүргэнэ.
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн санг хөгжүүлж, гүйцэтгэл үр дүнг сайжруулж, орон нутаг дахь хяналт шалгалт, зөвлөн туслах ажлын үр дүнг нэмэгдүүлнэ.
- Хууль сахиулах байгууллагын салбарын хөгжлийг дэмжиж ажиллана.
- Төсөв, санхүүгийн хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллана.
- Аймаг, сум, нийгэм, эдийн засгийн зарим салбар байгуулагдсаны түүхт ой угтсан бүтээлч ажлуудыг санаачилж өрнүүлнэ.
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- Иргэндээ үйлчилдэг ил тод, үр нөлөөтэй ухаалаг төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж Төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо, хамтын ажиллагааг сайжруулна.
- Цэргийн албаны тухай хуулийн дагуу тоо бүртгэл, цэрэг татлага, хяналт шалгалтыг зохион байгуулна.
- Хуулийн салбарын хүрээний чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэн сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.
- Санхүүгийн сахилга баттай ажиллана.
- Аймгийн Засаг даргын ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Төв аймгийн Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, хэрэгжүүлэх 45 арга хэмжээтэй баталснаас нийт 92,0 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Засаг даргын тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Төв аймгийн Засаг даргын тамгын газарт дотоод аудитын нэгж байхгүй ба Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Тамгын газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/66 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталж Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Засаг даргын тамгын газарт аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагад өдөр тутам мөрдөгддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 213,945.6 мянган төгрөгөөр буюу 6,2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	4,015.6	129,039.1	125,023.4
Бараа материал	168,996.7	208,471.5	39,474.8

Үндсэн хөрөнгө	3,254,718.5	3,304,165.9	49,447.4
Нийт хөрөнгө	3,427,730.9	3,641,676.6	213,945.6
Өр төлбөр	210.0	455.4	245.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,427,520.9	3,641,221.1	213,700.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,427,730.9	3,641,676.6	213,945.6

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд авлага данс эцсийн үлдэгдэл 129,039.1 мянган төгрөг болж нэмэгдсэн нь 100 жилийн ойн тоглолтын билетийн үнэ, баримтат кино, ном, телевизийн нэвтрүүлгийн урьдчилгаа төлбөрийн авлага үүсгэснээс шалтгаалсан байна. Бараа материал дансны эхний үлдэгдэл 168,996.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 208,471.5 мянган төгрөг болж 39,474.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн үнэ төлбөргүй болон худалдан авсан аж ахуйн бараа материалтай холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 3,254,718.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 3,304,165.9 мянган төгрөг болж, 49,447.4 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан үндсэн хөрөнгө болон хасагдсан үндсэн хөрөнгөөс гадна элэгдлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,641,221.1 мянган төгрөг болж 213,700.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,984,055.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн байна.

Төв аймгийн Засаг даргын тамгын газраас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн төсвийн төслийн дүнг 1,150,080.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2022 оны урсгал зардлын төсвийг 4,134,136.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 4,134,136.5 мянган төгрөгт 1 удаа тодотгол хийж 3,035,142.3 мянган төгрөгөөр баталж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,035,142.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 2,952,882.9 мянган төгрөгийг зарцуулж, 82,259.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,952,882.9 мянган төгрөг буюу 97,3 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,310,995.7	1,299,184.4	11,811.2	99.1%
2	70106/80102 Туслах үйл ажиллагааны зардал	231,731.4	218,509.0	13,222.3	94.3%
3	70106/80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	393,862.7	361,537.0	32,325.6	91.8%
4	70106/80219 Харуул, хамгаалалтын зардал	31,655.0	29,597.4	2,057.6	93.5%

5	70106/80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал, урамшуулал	62,691.7	57,529.2	5,162.5	91.8%
6	70106/80918 Бусад	60,000.0	60,000.0	0.0	100.0%
7	70106/81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	894,205.8	876,525.9	17,679.8	98.0%
8	70106/82801 Улсын их баяр наадам	50,000.0	50,000.0	0.0	100.0%
	ДҮН	3,035,142.3	2,952,882.9	82,259.4	97.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд газрын дуудлага худалдааны орлого 1,334,735.8 мянган төгрөг, 100 жилийн ойн тоглолтын билетийн үнэ 41,890.0 мянган төгрөг, номын үнэ 2,520.0 мянган төгрөг, худалдааны орлого 4,000.0 мянган төгрөг, заалны түрээсийн орлого 100.0 мянган төгрөг, сургалтын төлбөр 1,620.0 мянган төгрөг, татварын буцаан олголт 1,727.6 мянган төгрөг, үнэт цаасны орлого 1,030.2 мянган төгрөг, хандив 33,000.0 мянган төгрөг, буудлын орлого 287.9 мянган төгрөг, дээд газраас 207,863.6 мянган төгрөг, нийт 1,628,775.2 мянган төгрөгийн орлого орсноос цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 17,489.9 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах зардалд 10,939.5 мянган төгрөг, урсгал засварын зардалд 429,312.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 467,810.4 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 62,899.6 мянган төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 134,900.0 мянган төгрөг, бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардалд 9,999.0 мянган төгрөг, нийт 1,133,350.6 мянган төгрөгийг зарцуулж, 495,424.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Хөтөлбөр 92.0 %	3,035,142.3	2,952,882.9

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны 03/04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Засаг даргын тамгын газрын батлагдсан 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 6,350,339.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 95,255.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 71,441.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Засаг даргын тамгын газарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад мэдээлбэл зохих 171 мэдээллээс 12 мэдээллийг хугацаа хоцроосон, мэдээлээгүй мэдээлэл байхгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж, 3 албан шаардлага өгснийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 02/1072 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	3	176,001.9	3	176,001.9	100%
Зөвлөмж	1	87,126.9	1	87,126.9	100%
Нийт дүн	4	263,128.8	4	263,128.8	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгийн тооллого, тооцоо бодолтыг авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 93,420.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залрууллаа. Үүнд:

Тайлант хугацаанд 7 аж ахуйн нэгжтэй холбоотой 93,420.0 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөрийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгэр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.2 Албан шаардлага

1. Төв аймгийн Засаг дарга нь 2 орлогчтой ажиллаж байгаад нийгмийн салбар хариуцсан орлогч Ц.Буманбуянг 2022 оны 11 дүгээр сард орлогчийн албан тушаалаас чөлөөлж, засаг даргын зөвлөхөөр томилсон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д “Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно”, 5.4-д “Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

2. Нийт 3 аж ахуйн нэгжтэй холбоотой 101,650.0 мянган төгрөгийн худалдан авалтыг худалдан авах ажиллагаа зарлалгүй хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.9-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

3. Засаг даргын нөөцөөс нийт 54,743.0 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зүйлс худалдан авахад, 42,382.4 мянган төгрөгийг баяр наадмын зардлуудад тус тус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1-д “Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна”, 2.1.5-д “энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

4. Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг цахим төлбөрийн баримттай тулгалт хийхэд цахим баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 510,607.1 мянган төгрөгөөр дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5-д Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын кассаар нийт 86,358.5 мянган төгрөгийг бэлнээр гарган зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 6.3-д “Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ- 500,000 (таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид кассын тайланг сар бүр гаргаж байх, мөнгөн урьдчилгааны тайлан гаргаж байх, “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Зардлын эдийн засгийн ангилал зөрчин нийт 50,568.0 мянган төгрөгийн гүйлгээг хийсэн байна. Үүнд: 80219-Харуул, хамгаалалтын зардал, 210801-Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр гэсэн хөтөлбөр, арга хэмжээнээс 29,597.4 мянган төгрөгийн урсгал засвар, бараа материал худалдан авах, хүндэтгэл үзүүлэх, хоолны үнэ, спорт заалны түрээс, түлш халаалтын зардлаас 2,150.0 мянган төгрөгийг албан хаагчдын түлээ нүүрсний хөнгөлөлтөд, мэдээлэл технологийн зардлаас 18,820.6 мянган төгрөгийг шуудан холбоо, интернэтийн төлбөр, тоног төхөөрөмж худалдан авахад тус тус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлс эн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруу лаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	То о	Д үн	Тоо	Дүн
Авлага тусгаагүй	1	93,420.0	1	93,420.0			1	93,420.0				
Дүн	1	93,420.0	1	93,420.0			1	93,420.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт	Тоо	Дүн

									Н Ы Т О О		
Засаг дарга нь 2 орлогчийн 1- ийг зөвлөхөөр томилсон.	1	10,962.1			1	10,962.1					
Тендер зарлалгүй худалдан авалт хийсэн	1	101,650.0			1	101,650.0					
Засаг даргын нөөцөөс бэлэг дурсгалын зүйлс, баяр наадмын зардлуудад зарцуулсан	1	97,125.4			1	97,125.4					
Худалдан авалтууд төлбөрийн цахим баримтаар баталгаажуу гүй.	1	510,607.1			1	510,607.1					
Кассаар бэлнээр гарган зарцуулсан	1	86,358.5					1	86,358.5			
Эдийн засгийн ангилал зөрсөн	1	50,568.0					1	50,568.0			
Дүн	6	857,271.1			4	720,344.6	2	136,926.5			